



АйЖЭИ ЭЙЭЧ-Аудит ХХК

“Дархан Сэлэнгийн Цахилгаан түгээх сүлжээ” ХК

2019 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон
Санхүүгийн аудитын тайлан

Улаанбаатар хот
2020

АГУУЛГА

КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ.....	2
УДИРДЛАГЫН ХАРИУЦЛАГЫН ЗАХИДАЛ	3-4
ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	5-6
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН	7
ОРЛОГЫН ТАЙЛАН	8
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН.....	9
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН.....	10-11
ТОДРУУЛГА 1. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	12
ТОДРУУЛГА 2. САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ЗАРЧИМ.....	13-19
ТОДРУУЛГА 3. ҮЛДЭГДЭЛ ТЭНЦЛИЙН ТАЛААР	19-23
ТОДРУУЛГА 4. БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО	203
ТОДРУУЛГА 5. БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ӨРТӨГ.....	23-24
ТОДРУУЛГА 7. БУСАД ЗАРДАЛ	24
ТОДРУУЛГА 8. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО,ЗАРДАЛ	224
ТОДРУУЛГА 9. САНХҮҮГИЙН ОРЛОГО, ЗАРДАЛ.....	25
ТОДРУУЛГА10. ТАТВАРЫН ТООЦООЛОЛ	25
ТОДРУУЛГА 11. ХОЛБООТОЙ ТАЛУУД.....	25
ТОДРУУЛГА 12. БОЛЗОШГҮЙ ЗҮЙЛ.....	25
ТОДРУУЛГА 13. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВЦ.....	26

КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ

Компанийн нэр /Оноосон нэр/	Монгол	"Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ" ХК
Компанийн удирдлага	С.Нэргүй	Гүйцэтгэх захирал
Компанийн хаяг:	Монгол Улс, Дархан-уул аймаг, Дархан сум, 3-р баг Утас: (976)-70376580,70377741	
Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар:	9010001004	
Регистрийн дугаар:	2688565	
Бүртгэгдсэн он сар	2005 он	
Үйл ажиллагааны чиглэл	Цахилгаан эрчим хүч түгээх, зохицуулалттай хангах	
Санхүү	М.Гэрэлмаа	Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга, ерөнхий нягтлан бодогч
Ажилчдын тоо	420 гаруй ажилчидтай	
Аудитын компани	"Ай Жэй Эй Эйч -Аудит" ХХК Нягтлан бодох бүртгэл, татвар, санхүүгийн хяналт баталгаажуулалтын итгэмжлэгдсэн хөндлөнгийн байгууллага	
Аудитын компанийн хаяг	Монгол улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 15-р хороо, "Cooper plaza" төв 502,503 тоот Утас: 77450279, 99040059	

2019 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн тайлан бэлтгэх болон батлах талаарх удирдлагын хариуцлагын мэдэгдэл

Энэхүү тайлангийн 5-7 дахь хуудсанд тусгагдсан хараат бус аудиторын тайланда дурдсан хараат бус аудиторын дүгнэлттэй хамт уншигдах дараах мэдэгдэл нь “Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ” Хувьцаат Компанийн 2019 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн тайлантай холбоотой удирдлагын үүрэг хариуцлага болон аудиторын хяриуцлагыг ялгах үүднээс хийгдсэн болно.

Удирдлага нь компанийн санхүүгийн тайлангуудыг СТОУС-ын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй бөгөөд эдгээр санхүүгийн тайлангууд нь 2019 оны 12-р сарын 31-нээрх санхүүгийн байдал, тайлант жилийн санхүүгийн гүйцэтгэл, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийг СТОУС-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байх ёстой.

Санхүүгийн тайланг бэлтгэхэд удирдлага нь дараах зүйлсэд хариуцлага хүлээдэг.

Үүнд:

- ✓ Тохиромжтой нягтлан бодох бүртгэлийн бодлого сонгож, туштай мөрдөх
- ✓ Ул үндэстэй, хянамгай шийдэл гаргах болон тооцоолол хийх
- ✓ СТОУС-ыг дагаж мөрдсөн эсэхээ дурдаж, хэрэв материаллаг ялгаа буюу өөрчлөлт байгаа бол санхүүгийн тайланда тодруулж, тайлбарлах
- ✓ Компани ойрын ирээдүйд бизнесээ үргэлжлүүлнэ гэсэн тесээлэл нь тохиромжгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайланг үйл ажиллагааны суурийг үндэслэж бэлтгэх

Удирдлага нь түүнчлэн,

- ✓ Дотоод хяналтын үр дүнтэй, туштай систем боловруулж, хэрэгжүүлж ажиллуулах
- ✓ Компанийн санхүүгийн байдлыг аливаа хугацаанд үнэн зөвөөр харуулахуйц нягтлан бодох бүртгэл хөтлөх
- ✓ Компанийн нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь санхүүгийн тайланг СТОУС-ын дагуу бэлтгэхүйцээр зохион байгуулагдсан байх
- ✓ Хөрөнгийн хадгалалт, хамгаалалтыг хангах арга хэмжээ авч хэрэгжүүлэх
- ✓ Заль мэхний асуудал, алдаа болон бусад зөрчлийг илрүүлэх, тэдгээрээс урьдчилан сэргийлэх зэрэг үүрэг хүлээдэг.

Бид эдгээр үүрэг хариуцлагаа ухамсарлан, санхүүгийн тайлангаа Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт, Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох заавар журмын дагуу үнэн зөв бэлтгэсэн гэдгээ баталж байна.

“Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ” ХК-ийн 2019 оны 12-р сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн санхүүгийн тайланг гаргахыг зөвшөөрч батлав.

.....
С.Нэргүй
Гүйцэтгэх захирал

.....
М.Гэрэлмаа
Няглан бодогч



НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ, ТАТВАР, САНХҮҮГИЙН ХЯНАЛТ
БАТАЛГААЖУУЛАЛТЫН ИТГЭМЖЛЭГДСЭН ХӨНДЛӨНГИЙН БАЙГУУЛЛАГА

“Ай Жэй Эй Эйч-Аудит” ХХК

20.00 он 03. сар 30. өдөр

№ 93/2020

Улаанбаатар хот

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

“Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ” ХК-ийн хувьцаа эзэмшигч танаа

Санхүүгийн тайлангийн аудитын талаарх тайлан

“Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ” ХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр тасалбар болсон хугацааны орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдэх санхүүгийн тайланд аудит хийлгээ.

Бидний дүгнэлтээр, эдгээр санхүүгийн тайлангууд нь бүх материаллаг зүйлсийн хувьд “Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ” ХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тухайн өдрөөр дуусгавар болгосон тайлант жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартуудын дагуу үнэн зөв толилуулсан байна.

Аудитын дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандартуудын дагуу хийж гүйцэтгэв. Эдгээр стандартуудын дагуу хүлээх хариуцлагаа энэ тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага гэсэн хэсэгт харуулав. Бид санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой зохих ёс зүйн шаардлагуудын дагуу компаниас хараат бусаар ажиллах үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэнд хангалттай бөгөөд зохистой үндэслэл болж чадсан гэдэгт итгэлтэй байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шүүмжээр аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайланд хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа тусдаа дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайлангийн талаархи компанийн удирдлагын хариуцлага

Эдгээр санхүүгийн тайланг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулах нь удирдлагын үүрэг хариуцлага юм. Зальт ажиллагаа буюу алдаанаас үүдсэн материаллаг буруу илэрхийллээс ангид санхүүгийн

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (үргэлжлэл)

тайланг бэлтгэж, үнэн зөв толилуулахтай холбогдсон дотоод хяналтыг төлөвлөх, хэрэгжүүлэх мөрдөх, нягтлан бодох бүртгэлийн зохих бодлогыг сонгож, хэрэглэх, тухайн нехцөл байдалд үндэслэлтэй нягтлан бодох бүртгэлийн тооцооллыг хийх нь энэхүү хариуцлагад хамаарна. Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага компанийн тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлыг тодруулсан ба цаашид компани үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах үүрэг хариуцлагыг хүлээсэн байна.

Санхүүгийн тайлангийн талаархи аудиторын хариуцлага

Бидний үүрэг хариуцлага бол гүйцэтгэсэн аудитын ажилдаа тулгуурлан эдгээр санхүүгийн тайлангуудад дүгнэлт гаргах явдал юм. Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэлээ. Эдгээр стандарт нь санхүүгийн тайлангууд материалын зөрчилгүй илэрхийлэгдсэн гэсэн зохих нотолгоог олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх болон мэргэжлийн ёс зүйн шаардлагуудыг даган мөрдөхийг биднээс шаарддаг.

Аудитын үед санхүүгийн тайлангууд дахь дүн мэдээ болон тодруулгын талаар аудитын нотолгоо олж авахад чиглэгдсэн горимуудыг гүйцэтгэсэн. Эдгээр горимуудыг аудиторын шийдэлд суурилан сонгодог бөгөөд үүнд, залилан юмуу алдаанаас үүдэлтэй материалын буруу илэрхийллийн эрсдлийн тооцоолол багтдаг. Эдгээр эрсдлийн үнэлгээг хийхтэй холбоотойгоор, аудитор компанийн дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд нь дүгнэлт өгөх зорилгоор бус харин тухайн нехцөл байдалд тохирсон аудитын горимыг тодорхойлохын тулд тухайн компанийн санхүүгийн тайланг бэлтгэж үнэн зөвөөр илэрхийлэхтэй холбоотой дотоод хяналтыг авч үздэг. Түүнчлэн санхүүгийн тайлагналыг ерөнхийд нь үнэлэхээс гадна, удирдлагын зүгээс хийсэн томоохон тооцооллууд болон хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын ул үндэстэй бөгөөд тохиромжтой байдлыг үнэлэх ажлыг бидний аудит багтаасан. Мөн нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн компани үйл ажиллагаагаа тасралтгүй үргэлжлүүлэн явуулах чадамжтай холбоотой материалын тодорхой бус байдал байгаа эсэхийг тодорхойлсон.

Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг Монгол Улсын “Компанийн тухай хууль”-ийн 4-р зүйлд заасан хуулийн этгээд болох “Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ” ХК-ийн хувь нийлүүлэгчдэд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.



Огноо: 2020. 03. 30

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2019 оны 12 сарын 31-иээр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
ХӨРӨНГӨ		
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгөн хөрөнгө	286,766,587.49	390,315,270.62
Авлага	1,989,451,050.24	1,837,657,924.90
Татвар, НДШ-ийн авлага	129,296,693.48	116,954,868.42
Бусад авлага	1,077,270,682.36	4,568,461,502.48
Бараа материал	2,926,238,967.72	1,545,001,708.54
Урьдчилж төлсөн зардал/ тооцоо	212,347,921.39	133,794,177.43
Эргэлтийн хөрөнгийн дүн	6,621,371,902.68	8,592,185,452.39
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	77,970,456,463.23	75,903,122,289.46
Биет бус хөрөнгө	94,713,470.50	572,437,126.85
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	78,065,169,933.73	76,475,559,416.31
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	84,686,541,836.41	85,067,744,868.70
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
Богино хугацаат өр төлбөр		
Дансны өглөг	5,350,615,362.24	5,646,449,099.08
Цалингийн өглөг	529,250,413.09	443,482,774.77
Татварын өглөг	805,754,221.25	871,792,905.70
Нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг	184,991,967.57	294,953,471.58
Ноогдол ашгийн өглөг	168,567,832.06	-
Богино хугацаат өр төлбөрийн дүн	7,039,179,796.21	7,256,678,251.13
Үрт хугацаат өр төлбөр		
Үрт хугацаат зээл	28,230,141.84	26,058,593.16
Хойшлогдсон татварын өр	13,252,861,844.89	12,836,941,951.38
Үрт хугацаат өр төлбөрийн дүн	13,281,091,986.73	12,863,000,544.54
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	20,320,271,782.94	20,119,678,795.67
Эздийн өмч		
Өмч / хувийн /	1,038,511,576.99	1,038,511,576.99
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	63,103,330,971.93	63,103,330,971.93
Хуримтлагдсан ашиг, (алдагдал)	224,427,504.55	806,223,524.11
Эздийн өмчийн дүн	64,366,270,053.47	64,948,066,073.03
Нийт өр төлбөр, өмчийн дүн	84,686,541,836.41	85,067,744,868.70

Нэмэлт тодруулгууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно

УЧЛАНЫА СТАР ЛОУ

ОРЛОГЫН ТАЙЛАН


2019 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

2019 оны 12-р сарын 31

Борлуулалтын орлого	89,953,575,334.43
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	69,675,718,454.45
Нийт ашиг (алдагдал)	20,277,856,879.98
Түрээсийн орлого	26,859,318.00
Хүүний орлого	7,923,841.65
Бусад орлого	1,484,361,828.23
Борлуулалт маркетингийн зардал	9,121,846,545.41
Ерөнхий ба удирдлагын зардал	11,021,427,199.47
Санхүүгийн зардал	60,923,663.02
Бусад зардал	872,026,390.69
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарэ)	(1,082,694.02)
Үндсэн хөрөнгө данснаас хассаны (гарэ)	(66,736,231.11)
Бусад ашиг /алдагдал/	
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	652,959,144.14
Орлогын татварын зардал	71,163,124.58
Татварын дараах ашиг (алдагдал)	581,796,019.56
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	581,796,019.56

Нэмэлт тодруулгууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно




ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН
2019 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

	Хувьцаат капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагд- сан ашиг	Нийт дүн
2018 оны 12-р сарын 31	1,038,511,576.99	63,103,330,971.93	224,427,504.55	64,366,270,053.47
Гаргасан хувьцаат капитал	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	-	-	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал			581,796,019.56	581,796,019.56
Бусад дэлгэрэнгүй орлого				
2019 оны 12-р сарын 31	1,038,511,576.99	63,103,330,971.93	806,223,524.11	64,948,066,073.03

Нэмэлт тодруулгууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салишгүй хэсэг болно.



МОНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН
2019 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон тайлан

Төгрөгөөр/

2019 оны 12-р сарын 31

Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ

Мөнгөн орлогын дүн (+)

75,425,969,247.59

Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого

73,848,827,650.39

Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө

3,148,314.00

Бусад мөнгөн орлого

1,573,993,283.20

Мөнгөн зарлагын дүн (-)

72,419,198,238.35

Ажилчдад төлсөн

6,098,963,747.61

Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн

1,848,028,551.94

Бараа материал худалдан авахад төлсөн

4,625,315,373.34

Ашиглалтын зардалд төлсөн

10,575,790.82

Түвш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн

923,169,233.00

Хүүний төлбөрт төлсөн

676,957.33

Татварын байгууллагад төлсөн

2,749,703,794.62

Даатгалын төлбөрт төлсөн

2,168,000.00

Бусад мөнгөн зарлага

56,160,596,789.69

Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн

3,006,771,009.24

Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ

Мөнгөн орлогын дүн (+)

7,923,831.65

Хүлээн авсан хүүний орлого

7,923,831.65

Мөнгөн зарлагын дүн (-)

2,733,204,083.00

Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн

2,183,056,778.00

Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн

550,147,305.00

Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн

(2,725,280,251.35)

Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ

Мөнгөн орлогын дүн (+)

(5,761,293.93)

Төрөл бүрийн хандив

(6,120,000.00)

Валютийн зөрүүний орлого

358,706.07

Мөнгөн зарлагын дүн (-)

172,180,780.83

Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө

2,171,548.68

Телсэн ногдол ашиг	168,567,832.06
Валютийн зөрүүний алдагдал	1,441,400.09
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(177,942,074.76)
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	103,548,683.13
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	286,766,587.49
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	
<i>Нэмэлт тодруулгууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.</i>	



ТОДРУУЛГА 1. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ БА ҮЙЛ АЖИЛЛАГАА

“Дархан Сэлэнгийн Цахилгаан түгээх сүлжээ” ХК нь БНМАУ –ын Сайд нарын зөвлөлийн 1965 оны 155 дугаар тогтоолоор “Дархан Сэлэнгийн цахилгаан шугам сүлжээний газар” нэртэй анх байгуулагдан, Монгол улсын Засгийн газрын 2001 оны 164 дүгээр тогтоолоор “Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ” нэртэй ТӨХК болж өөрчлөн зохион байгуулагдсан. Засгийн газрын 2003 оны 14-р тогтоолыг үндэслэн, Төрийн өмчийн хорооноос зарласан нээлттэй тендер шалгаруулалтаар тус компаний төрийн эзэмшилийн 10,385,116 ширхэг хувьцааг “Хасвуу” ХХК 3,600,000.000 / Гурван тэрбум зургаан зуун сая/ төгрөгөөр худалдан авсан. Бүтэц зохион байгуулалтын хувд бодлого зохицуулалтын 4 хэлтэс, мэдээлэл, шуурхай удирдлага, засвар, хэмжүүр, үйлчилгээ, хяналтын чиглэлийн 6 алба, цахилгаан тоног төхөөрөмжийн ашиглалт, борлуулалтын ажлыг гүйцэтгэх 4 салбар, хэрэглэгчдэд үйлчлэх 2 төвтэй, нийт 420 гаруй ажилтантай. Сэлэнгэ, Дархан уул аймгийн бүх сум, суурин газар, Төв аймгийн 6 сум, нийт 74000 км² нутаг дэвсгэрт орших аж ахуйн нэгж, байгууллага, айл өрхөд цахилгаан эрчим хүчийг түгээж, ханган борлуулах үйл ажиллагааг явуулж байна. Ингэхдээ Эрчим хүчний яам, Эрчим хүчний Зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн дагуу дараах үйл ажиллагааг явуулж байна.

- Цахилгаан эрчим хүч түгээх
- Цахилгаанаар зохицуулалттай хангах
- 5-100 MB т-ын эрчим хүчний эх үүсвэр барих, угсрах, засварлах
- 0,4-220 КВ болон түүнээс дээш цахилгаан дамжуулах шугам, дэд станцын угсралт, засвар
- ЦЭХ-ний 1 ба 3 фазын тоолуурын шалгалт, тохируулга, сууринуулалт
- Туршилт тохируулгын ажил үйлчилгээ / 2 догч коммутицийн ажлууд болон хэмжилт туршилт тохируулгын бүх төрлийн ажлууд/
- 0,1-100 MB т-ын эрчим хүчний эх үүсвэрийн ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах
- Цахилгаан дамжуулах шугам, дэд станцын ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах /110 КВ –аас дээш/
- Бусад дагалдах ажил үйлчилгээ / өрлөг, дулаалга, бэхэлгээ болон тулгуур хийц хэсгийн үйлдвэрлэлт, нийлүүлэлт/

ТОДРУУЛГА 2. САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ЗАРЧИМ

Нягтлан бодох бүртгэлийн үндэс

Энэхүү санхүүгийн тайланг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт цаашид (СТОУС гэх), Олон улсын санхүүгийн тайлагналын стандартын Тайлбарын байнгын хорооноос баталсан тайлбар болон Монгол улсын зохих хууль ,тогтоомжийг үндэслэн бэлтгэсэн.

Үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг бэлтгэсэн валют

Компанийн үйл ажиллагааны валют нь Монгол улсын үндэсний валют төгрөг юм.

Үнэлгээ

Үндсэн хөрөнгөөс бусад зүйлсийг санхүүгийн тайлагналын түүхэн өртгийн зарчимд тулгуурлан бэлтгэсэн ба үндсэн хөрөнгийг 2014 онд Лэндс ХХК-иар дахин үнэлүүлсэн.

Нягтлан бодох бүртгэлийн суурь

Компани нягтлан бодох бүртгэлийн аккурэль суурьд үндэслэн санхүүгийн тайлангаа бэлтгэдэг.

Санхүүгийн тайлан бэлтгэх төсөөлөл

Компани одоо болон алс ирээдүйд үйл ажиллагаагаа тасралтгүй үргэлжлүүлнэ гэсэн төсөөлөлд үндэслэн санхүүгийн тайлангаа бэлтгэнэ. Хэрэв удирдлага байгууллагыг татан буулгах, эсвэл үйл ажиллагааг нь зогсоохор санаархаж байгаа буюу үүнээс өөр бодоит боломжгүй байхаас бусад тохиолдолд өрөнхий зорилготой санхүүгийн тайлангуудыг тасралтгүй байх зарчмын дагуу бэлтгэдэг. Тасралтгүй байх зарчмыг хэрэглэх нь зохимжтой бол тухайн байгууллага бизнесийн хэвийн явцад хөрөнгөө хэрэгжүүлж, өр төлбөрийг барагдуулах боломжтой байна гэсэн үндэслэлээр хөрөнгө ба өр төлбөрийг бүртгэдэг.

Тайлангийн хугацаанд шинээр ашиглаж эхэлсэн болон сайжруулалт хийгдсэн стандартууд

СТОУС	2016 оны 12 дугаар сарын 31 нээрх шинэ СТОУС, болон нэмэлт өөрчлөлтүүд	Хүчин төгөлдөр мөрдөгдөх хугацаа
СТОУС 9 Санхүүгийн хэрэглүүр	СТОУС 9 санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийг ангилах хэмжих болон данснаас хасах асуудлыг хамаарах бөгөөд хэйджийн нягтлан бодох бүртгэл болон санхүүгийн хөрөнгийн үнийн бууралтын шинэ загварыг танилцуулдаг. СТОУС 9-д аажмаар шилжих үйл явцыг 2015 оны 2 сарын 1 нээс өмнөх санхүүгийн жилүүдэд хийхийг зөвшөөрсэн ба уг хугацаанаас хойш шинэ заалтуудыг бүрэн мөрдөх ёстой. СТОУС 9-ийн заавал хэрэглэх	Уг стандартыг 2018 оны 1 дүгээр сарын 1-ээс эхлэх эсвэл түүнээс хойших санхүүгийн жилүүдэд заавал хэрэглэхийг шаардана.

	хугацаанаас өмнө уг стандартыг хэрэглэхгүй гэж үзсэн.	
СТОУС 15 Үйлчлүүлэгчтэй хийсэн гэрээний орлого	ОУНББСХ нь орлогыг хүлээн зөвшөөрөх шинэ стандартыг гаргасан. Энэ стандарт нь бараа, үйлчилгээний гэрээнд НББОУС 18-ыг, харин барилгын гэрээнд НББОУС 11 –ийг бүрэн орлоно. Шинэ стандарт нь бараа эсвэл үйлчилгээний хяналт нь үйлчлүүлэгчид шилжсэн үед орлогыг хүлээн зөвшөөрөх зарчимд сууриссан. Стандартыг бүрэн эсвэл өөрчлөн хэрэглэхийн аль алиныг зөвшөөрсэн.	2018 оны 1 дүгээр сарын 1, эсвэл түүнээс хойш эхлэх санхүүгийн жилүүдэд заавал хэрэглэнэ. Энэ стандартыг 2018 оны 1 дүгээр сарын 1 ээс хэрэгжүүлж эхлэхээр тооцож байгаа.
СТОУС 16 Түрээс	СТОУС 16 нь 2016 оны 1 сард гарсан. Түрээсийг үйл ажиллагааны болон санхүүгийн түрээс гэж ангилхаар заасныг хассан бөгөөд ингэснээр бүх түрээс балансад тусгагдана. Шинэ стандарттаар хөрөнгө /түрээслэсэн зүйлсийг ашиглах эрх/ болон түрээсийн төлбөрийг төлөх санхүүгийн өр төлбөрийг хүлээн зөвшөөрне. Харин богино хугацаатай болон бага үнэ цэнэтэй түрээсийн хувьд хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрийг бүртгэхгүй. Түрээслүүлэгчийн няглан бодох бүртгэлд томоохин өөрчлөлт гараагүй.	Шинэ стандартыг 2019 оны 1 дүгээр сарын 1 эсвэл түүнээс хойш хугацаанд эхэлсэн санхүүгийн жилүүдэд заавал хэрэглэнэ. Энэ хугацаанаас өмнө хэрэглэхгүй

Хараахан хэрэгжиж эхлээгүй бөгөөд энэ эсвэл ирээдүйн тайлант жилүүдэд болон таамаглаж болох ирээдүйн ажил гүйлгээнд материаллагаар нөлөөлөх өөр бусад стандартууд байхгүй байна.

Санхүүгийн хэрэглүүр

Санхүүгийн үндсэн хэрэглүүрүүдэд дараах хэрэглүүрүүдийг хамруулна.

- Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө
- Худалдааны ба бусад авлага
- Худалдааны ба бусад өглөг
- Банк санхүүгийн байгууллагаас авсан зээл

Санхүүгийн хөрөнгө

Санхүүгийн хөрөнгүүдийг бодит үнэ цэнэ болон шууд хамаарлтай ажил гүйлгээний зардлын нийлбэрээр анхлан хэмжинэ. Компанийн санхүүгийн хөрөнгө нь мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө болон худалдааны ба бусад авлагаас бүрдэнэ.

Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгөн гүйлгээний тайлангийн зорилгоор, мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөнд гар дээрх мөнгө, санхүүгийн байгууллагад хадгалагдаж байгаа мөнгө, бусад богино хугацаатай, З сар эсвэл түүнээс богино хугацаанд мөнгө болох чадвартай, үнийн өөрчлөлтөнд өртөмтгий бус хөрөнгө оруулалт болон банкны овердрафт багтана. Мөнгө түүнтэй адилтгах зүйлсийг нэрлэсэн үнээр бүртгэдэг. Гадаад валютаархи мөнгөн хөрөнгийг Монгол банкнаас зарласан албан ханшаар төгрөгт шилжүүлж бүртгэдэг.

Зээл ба авлага

Зээл ба авлагууд идэвхтэй зах зээл дээр бүртгэлгүй, тогтмол эсвэл тодорхойлж болох төлбөртэй, үүсмэл биш санхүүгийн хөрөнгүүд юм. Авлагыг дараа үеүүдэд нь үр ашигт хүүгийн арга ашиглан хорогдуулсан өртгөөс үнэ цэнийн бууралтыг хассан дүнгээр бүртгэнэ.

Үл хүлээн зөвшөөрөх, үнэ цэнэ буурах, хорогдуулгын хөтөлбөрийн үед үүссэн аливаа олз, гарзыг ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрнө. Дараах тохиолдолд санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрнө.

- Хөрөнгөөс орж ирэх мөнгөн урсгалыг хүлээж авах эрхийн хугацаа дууссан,
- Компани нь хөрөнгөөс орж ирэх мөнгөн урсгалыг авах эрхийг шилжүүлсэн тохиолдолд эсвэл дамжин өнгөрөх гэрээ хийн гуравдагч этгээдэд хоцроолгүйгээр орж ирэх мөнгөн урсгалыг бүрэн төлөх ба дараах нөхцөлүүдийг хангахад
 - Компани хөрөнгийн бүх эрсдэл, өгөөж болон хөрөнгийг шилжүүлээгүй боловч захирах эрхийг шилжүүлсэн байх
 - Компани хөрөнгийн эрсдэл, өгөөжийг бүрэн шилжүүлсэн байх.

Санхүүгийн өр төлбөр

Санхүүгийн өр төлбөрийг бодит өртөг дээр шууд хамааралтай ажил гүйлгээний зардлыг нэмсэн дүнгээр анхлан хүлээн зөвшөөрнө. Компанийн санхүүгийн өр төлбөрт худалдааны болон бусад өглөг зээл орно. Компанийн үндсэн үйл ажиллагаатай холбогдон зээлээр худалдан авсан бараа, материалын үнэ, хүлээн авсан үйлчилгээний үнэ болон үйл ажиллагааны зардыг хурумтлуулснаас үүссэн өглөгийг дансны өглөгөөр хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

Дансны өглөгийг худалдан авсан бараа, үйлчилгээний нэрлэсэн үнээр бүртгэдэг.

Зээл

Анх хүлээн зөвшөөрсний дараа хүүтэй зээлүүдийг дараагийн тайлант хугацаанд үр ашигт хүүгийн арга ашиглан хорогдуулсан өртгөөр нь хэмжинэ. Үр ашигт хүүгийн арга гэдэг нь санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн хорогдуулсан өртгийг тооцдог ба тухайн хугацаанд хамаарах хүүгийн орлого эсвэл хүүгийн зардлыг хуваарилдаг арга юм. Өр төлбөрийг үл хүлээн зөвшөөрөх мөн хорогдуулгын хөтөлбөрийн үед үүсэх аливаа олз гарзыг ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

Компанийн санхүүгийн өр төлбөрийг тус өр төлбөртэй холбоотой үүрэг хариуцлага цуцлагдсан, чөлөөлөгдсөн болон хугацаа нь дуусвар болсон үед үл хүлээн зөвшөөрнө.

Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Өмчийн хэрэглүүр дэх санхүүжигчийн хүүг багтаагаад ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээрх гэж ангилагдаагүй санхүүгийн хөрөнгүүдийн үнэ цэнэ тайлант хугацааны эцсээр буурсан шинж тэмдэг байгаа эсэхийг үнэлдэг.

Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнэ буурсныг дараах шинж тэмгүүд илэрхийлдэг.

Үнд:

- Өр төлөгч төлбөрөө төлөх чадваргүй болох эсвэл хууль зөрчсөн үйл ажиллагаа
- Ямар нэг байдлаар тоо дунд өөрчлөлт оруулж дахин зохион байгуулж байх
- Өр төлөгч эсвэл гаргагч дампууралд өртсөнийг илтгэх шинж байдал
- Зээлдэгч эсвэл гаргагчийн төлбөр төлөх байдалд сөрөг өөрчлөлтүүд гарсан
- Санхүүгийн хүндрэл гарсаны улмаас үнэт цаасны идэвхэй зах зээл байхгүй болсон.
- Бүлэг санхүүгийн хөрөнгөтэй холбоотой тооцоолж байсан мөнгөн урсгалд хэмжиж болохуйц бууралт гарсныг илтгэх хялбар олдож болохуйц тоо мэдээ байгаа

Санхүүгийн бус хөрөнгө

Материал үнэ бүхий зүйл

Бараа материалын зарцуулалтын өртгийг тооцож бүртгэлд тусгахдаа жигнэсэн дундаж өртгийн аргыг хэрэглэнэ. Жигнэсэн дундаж өртгийг материалын төрөл тус бүрээр нь тодорхойлно. Бараа материалыг шинээр орлого болгосон тухай бүрт жигнэсэн дундаж өртгийн дүнг шинэчлэн тодорхойлно.

Цэвэр боломжит үнэ цэнэ гэдэг нь бизнесийн хэвийн үйл ажиллагааны явцад борлуулахаар тооцсон үнээс түүнийг иж бүрдэл болгохоор тооцсон зардал ба борлуулалттай холбоотой тооцсон зардлуудыг хассан дүн юм. Өөрөөр хэлбэл бизнесийн хэвийн үйл ажиллагааны явцад бараа материалыг борлуулснаар хүлээн авахаар тооцоолсон цэвэр дүнг илэрхийлнэ.

Бодит үнэ цэнэ нь идэвхтэй зах зээлийн орчинд зохих мэдээлэлтэй, арилжаанд оролцоход бэлэн байгаа талуудын хооронд ижил төрлийн бараа материалыг солилцож болох дүнг илэрхийлнэ. Бараа материалын өртөг нь цэвэр боломжит үнээс их бол бараа материалын өртгийг бууруулж цэвэр боломжит үнэ цэнээр илэрхийлэх ба энэ нь хөрөнгийг борлуулахаар тооцоолж буй үнээс эсвэл ашигласнаас бий болох өгөөжөөс дээгүүр үнээр үнэлэгдэх боломжгүй гэсэн зарчимд үндэслэгдэнэ.

Үндсэн хөрөнгө

Бүх үндсэн хөрөнгө түүхэн өртгөөс элэгдлийг хассан дүнгээр тусгагдана. Түүхэн өртөгт хөрөнгийг худалдан авахтай шууд холбоотой зардлууд багтана. Мөн

өртөгт гадаад валютаар худалдан авсан үндсэн хөрөнгийн мөнгөн урсгалыг хэйджийн олз/ гарзын өмчийн дүнгээс шилжүүлсэн хэсэг орно.

Дараа үеийн зардлуудыг хөрөнгийн дансны үнэд багтаах эсвэл тухайн хөрөнгөтэй холбоотой эдийн засгийн өгөөжийг хүртэх боломжтой, өртгийг найдвартай тооцох боломжтой бол тусдаа хөрөнгөөр бүртгэнэ. Бусад засвар үйлчилгээтэй холбоотой гарсан зардлыг гарсан үед нь тайлант хугацааны ашиг алдагдлын тайланд тусгана.

Данснаас хассанаас үүссэн олз, гарзыг хөрөнгийн дансны үнийг хүлээн авсан төлбөртэй нь харьцуулан тодорхойлох ба тэдгээрийг ашиг алдагдлын тайланд тусгана.

Үндсэн хөрөнгийн элэгдэл

Үндсэн хөрөнгийн элэгдлийг шулуун шугамын аргаар байгуулдаг. Үндсэн хөрөнгүүдийг Эрчим хүчний зохицуулах хорооны 2016 оны 2 дугаар сарын 04 нь 53 дугаар тогтоолоор батлагдсан “Эрчим хүчний тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох журам”-ын дагуу элэгдүүлдэг.

<u>Үндсэн хөрөнгийн төрөл</u>	<u>Элэгдүүлэх жил</u>
Барилга байгууламж	10-100 жил
Тавилга эд хогшил	5-10 жил
Машин, тоног төхөөрөмж	5-25 жил
Тээврийн хэрэгсэл	8-15 жил
Компьютер дагалдах хэрэгсэл	5 жил

Биет бус хөрөнгө

Тусад нь олж авсан биет бус хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөхдөө өртгөөр бүртгэдэг. Анх хүлээн зөвшөөрсний дараа биет бус хөрөнгийг өртгөөс хуримтлагдсан хорогдуулалт ба аливаа үнэ цэнийн бууралтын хуримтлагдсан алдагдлыг хассан цэвэр дүнгээр бүртгэнэ.

Өөрийн хөрөнгө

Өөрийн хөрөнгийн хэмжилт нь түүхэн өртгөөр байх ба энгийн хувьцааг нэрлэсэн үнээр нь бүртгэж өмчийн хэрэгслээр ангилдаг. Энгийн хувьцааг гаргахад шууд хуваарилагдах нэмэгдэл өртгийг аливаа татварын нөлөөг хассан дүнгээр нь хүлээн зөвшөөрсөн. Компани үүсгэн байгуулснаас хийш хугацаанд компанийд хуримтлагдсан ашиг, алдагдлын нийлбэрийг хуримтлагдсан ашиг дансанд бүртгэх ба оруулсан хөрөнгийг ашиглан бий болгосон нэмэлт эх үүсвэрийн хэмжээг харуулна.

Борлуулалтын орлого

Орлого нь мөнгөн хөрөнгө, авлага, бусад мөнгөн бус хэлбэрээр хэрэгжинэ. Хүлээн зөвшөөрсөн орлого нь эрх бүхий байгууллагаас баталсан үнэ эсвэл зах зээлийн худалдах үнээр буюу хүлээн авахаар тооцсон бодит үнэ цэнээр хэмжинэ.

Үйл ажиллагааны орлого, түүнтэй холбогдон худалдан авагч болон үйлчлүүлэгчидтэй үүссэн тооцоог НББ-ийн аккурэль зарчмаар бүртгэнэ. Аккурэль сууриар үйлчлүүлэгчид үйлчилгээ үзүүлж, бүтээгдэхүүн нийлүүлсэн тухайн үед борлуулалтын орлогыг хүлээн зөвшөөрч бүртгэнэ.

Зардал

Тайлант хугацаанд хувь нийлүүлэгчид хуваарилснаас бусад шалтгааны улмаас мөнгөний гадагш урсгал хэлбэрээр хөрөнгийг бууруулж, өр төлбөр ихэсгэдэг эдийн засгийн өгөөжийн бууралт гарах үед зардлыг хүлээн зөвшөөрдөг. Зардлыг тухайн гарсан жилд нь ашиг алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрнө.

Гадаад валютаарх ажил гүйлгээ

Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн хөрөнгө болон өр төлбөрийг тайлагналын өдрийн хаалтын ханшаар бүртгэлийн валют руу хөрвүүлэн илэрхийлдэг. Гадаад валютаар илэрхийлэгдсэн ба бодит үнэ цэнээрээ хэмжигдсэн мөнгөн бус хөрөнгө, өр төлбөрийг бодит үнэ цэнийг тодорхойлсон өдрийн албан ханшаар бүртгэлийн валют руу хөрвүүлэн бүртгэдэг. Гадаад валютаар илэрхийлэгдсэн ба түүхэн өртгөөр хэмжигдсэн мөнгөн бус зүйлсийг тухайн ажил гүйлгээ гарсан өдрийн албан ханшаар хөрвүүлдэг. Гадаад валютын ханшийн зөрүүг өрөнхийдээ ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрдөг.

Хүүгийн зардал

Бэлтгэл ажиллагаа шаардлагатай хөрөнгийг худалдан авах, барьж байгуулах эсвэл үйлдвэрлэхтэй шууд холбоотой тусгай болон ердийн зээлийн хүүгийн зардлыг ашиглах эсвэл борлуулахад бэлэн болгох зорилгоор хөрөнгийг бэлтгэх болон бүрэн дуусгахад шаардлагатай хугацааны туршид капиталжуулна. Бэлтгэл ажиллагаа шаардлагатай хөрөнгө гэдэг нь хөрөнгийг ашиглах эсвэл борлуулахад бэлэн болтол тодорхой хугацаа шаардлагатай хөрөнгийг хэлнэ. Бэлтгэл ажиллагаа шаардлагатай хөрөнгийн зарцуулалтанд тодорхой зээл авч богино хугацааны хөрөнгө оруулалт хийсэн хөрөнгө оруулалтын орлогыг капиталжуулах зээлийн хүүгийн зардлаас хасна. Зээллэгийн бусад бүх хүүгийн зардлыг тэдгээрийн гарсан тайлант хугацааных нь орлого үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрнө.

Орлогын албан татвар

Орлогын албан татварыг тайлант үеийн эцэст хүчин төгөлдөр хэрэгжиж байсан эсвэл ирээдүйд хэрэгжих хууль тогтоомжийн дагуу санхүүгийн тайлангуудад хүлээн зөвшөөрнө.

Компани нь хууль тогтоомжоор шаардсаны дагуу татвар, шимтгэлийн төлөлт, ногдуулалт, тайлагналтай холбоотой бүх тооцоолол, бүртгэлийг өөрсдөө дотооддоо хийж гүйцэтгэдэг.

Ажилчдын тэтгэмж

Ажилтан аж ахуйн нэгжид үзүүлсэн үйлчилгээний хариуд тайлант үеийн эцсээс хойших арван хоёр сарын хугацаанд багтаан авахаар тохиролцсон ажилтны тэтгэмж болох цалин, хөлс болон мөнгөн бус тэтгэмжүүдийг тайлант хугацааны эцсийг хүртэлх хугацаанд үзүүлсэн үйлчилгээнд суурilan хүлээн зөвшөөрөх ба төлбөрийг барагдуулах үед төлөгдөх дүнгээр хэмжинэ.

Ажилтны үйлчилгээ үзүүлсэн хугацаанаас хойш арван хоёр сараас илүү хугацаанд төлөгдөх бусад урт хугацааны тэтгэмжид удаан жил ажилласны тэтгэмж болон жилийн амралт зэрэг багтах ба төлөвлөсөн нэгжийн кредит аргыг ашиглан тайлант жилийн эцс хүртэл үзүүлсэн үйлчилгээтэй нь уялдуулан ирээдүйн тооцоолсон төлбөрийн өнөөгийн үнэ цэнээр хэмжинэ.

Болзошгүй өр төлбөр

Өнгөрсөн үйл явдлын үр дүнд хуулийн дагуу эсвэл үүсмэл үүрэг хариуцлага хүлээсэн болон хүлээсэн үүрэг хариуцлагын төлбөрийг барагдуулахад эдийн засгийн өгөөж бүхий нөөцийн урсгал гадагшлах магадлалтай болсон, мөн үүрэг хариуцлагын дүнг найдвартай тооцоолох боломжтой үед хуулийн зарга маргааны нэхэмжлэл, бүтээгдэхүүний баталгаа, гэрээний үүрэг хариуцлага зэргийг хүлээн зөвшөөрнө. Ирээдүйн үйл ажиллагааны алдагдалд зориулж болзошгүй өр төлбөрийг хүлээн зөвшөөрөхгүй

Холбоотой тал

Компанийн хяналтын багцыг эзэмшдэг иргэн, хуулийн этгээдийг холбоотой тал гэнэ. Холбоотой талыг тодорхойлоходоо хууль тогтоомжид үндэслэнэ.

ТОДРУУЛГА 3. ҮЛДЭГДЭЛ ТЭНЦЛИЙН ТАЛААР

2019 оны жилийн эцсийн байдлаар дараах санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрүүдийг эзэмшиж байна.

Хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгө:

/мянган төгрөгөөр/

	Тодруулга	2018	2019
Мөнгөтэй адилтгах хөрөнгө	3.1	286,766.6	390,315.3
Худалдааны авлага	3.2	1,989,451.0	1,837,657.9
Бусад авлага	3.2	1,206,567.4	4,685,416.4
Дүн		3,482,785.0	6,913,389.6

Хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн өр төлбөр:

	Тодруулга	2018	2019	/мянган төгрөгөөр/
Худалдааны өглөг	3.3	5,350,615.4	5,646,449.1	
Цалингийн өглөг	3.3	529,250.4	443,482.8	
Урьдчилж орсон орлого	3.3	-	-	
Урт хугацаат зээл	3.4	28,230.1	26,058.6	
Дүн		5,908,095.9	6,115,990.5	

ТОДРУУЛГА 3.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ

Тайлант хугацааны эцсээрх мөнгөн хөрөнгийн үлдэгдэл дараах байдалтай байна. Үүнд:

Үзүүлэлт	2018	2019	/мянган төгрөгөөр/
Кассанд байгаа бэлэн мөнгө (төгрөг)	2,723.0	1,880.0	
Бэлэн мөнгөний үлдэгдэл	2,723.0	1,880.0	
Банкин дахь төгрөгийн харилцах данс	284,043.6	388,435.3	
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн дүн	286,766.6	390,315.3	

Мөнгө нь касс дахь бэлэн мөнгө, төлбөр гүйцэтгэх зориулалттай банкин дахь төгрөгийн болон валютын харилцах дансуудаас бүрдсэн байна.

ТОДРУУЛГА 3.2. АВЛАГА

Үзүүлэлт	2018	2019	/мянган төгрөгөөр/
Дансны авлага	1,989,451.0	1,837,657.9	
ААНОАТ-ын авлага	129,296.7	97,498.0	
Холбоотой талаас авах авлага/эргэлтийн хөрөнгөнд хамаарах дүн/	1,040,610.7	1,736,859.6	
Ажиллагсдаас авах авлага	36,660.0	2,831,601.9	
Нийт Авлагын дүн	3,196,018.4	6,503,617.4	

Компанийн үндсэн үйл ажиллагааны хэрэглэгч нь цахилгаанаар хангагдаж байгаа аж ахуйн нэгж, төсөвт байгууллагууд, ахуйн хэрэглэгч нар байдаг. Сар бүр бичилт хийж авах авлагыг дансны авлагаар бүртгэж баталгаажуулдаг.

Бусад авлагаар аж ахуйн харилцаанаас үүссэн бусад бүх төрлийн авлагыг бүртгэдэг, авлагыг цугларах, төлөгдөх нөхцөл боломжийг харгалзан нягтлан бodoх бүртгэлийн бодлогын баримт бичигт зааснаар найдваргүй авлагын хасагдуулга тооцдог.

ТОДРУУЛГА 3.3. ӨР ТӨЛБӨР

Үзүүлэлт	2018	2019
	/мянган төгрөгөөр/	
Дансны өглөг	5,350,615.4	5,646,449.1
Суутгачийн хувь хүнд олгосон орлогоос сүтгасан	101,342.4	127,007.3
НӨАТ-ын өглөг	704,411.8	744,785.6
НДШ-ийн өглөг	184,992.0	294,953.5
Цалингийн өглөг	529,250.4	443,482.8
Ноогдол ашгийн өглөг	168,567.8	-
Богино хугацаат өр төлбөрийн дүн	7,039,179.8	7,256,678.3
Хойшлогдсон татварын өр төлбөр	13,252,861.8	12,836,941.9
Гадаадын байгууллагаас дамжуулан авсан зээл	28,230.1	26,058.6
Үрт хугацаат өр төлбөрийн дүн	13,281,091.9	12,863,000.5
Нийт өр төлбөрийн дүн	20,320,271.9	20,119,678.8

2019 оны жилийн эцсийн байдлаар дараах санхүүгийн бус хөрөнгө, өр төлбөрүүдийг эзэмшиж байна.

Санхүүгийн бус хөрөнгө

2018	2019	
	/мянган төгрөгөөр/	
Татвар, шимтгэлийн тооцоо	3.5	990,746.1
Бараа материал	3.6	2,926,329.0
Үндсэн хөрөнгө /цэвэр/	3.7	218,230,598.6
Биет бус хөрөнгө / цэвэр/	3.8	547,554.5
Санхүүгийн бус хөрөнгийн дүн	222,695,228.2	224,122,252.5

Санхүүгийн бус өр төлбөр

2018	2019	
	/мянган төгрөгөөр/	
Татвар шимтгэлийн тооцоо	3.5	990,746.1
Хойшлогдсон татварын өр	3.9	13,252,861.8
Санхүүгийн бус өр төлбөрийн дүн	14,243,607.9	14,000,688.3

ТОДРУУЛГА 3.5 ТАТВАР ШИМТГЭЛИЙН ТООЦОО

2018	2019	
	/мянган төгрөгөөр/	
НӨАТ -ын өглөг	704,411.8	744,785.6
ОАТ- ын өглөг	(129,296.7)	(116,954.9)
ХАОАТ-ын өглөг	101,342.4	127,007.3
ЭМНДШ-ийн өглөг	184,991.9	294,953.5
Нийт дүн	861,449.5	1,049,791.5

ТОДРУУЛГА 3.6 БАРАА МАТЕРИАЛ

	/мянган төгрөгөөр/	2018	2019
Бэлэн бүтээгдэхүүн		2,786,934.3	1,446,346.9
Хангамжийн материал		139,304.6	98,654.8
Бараа материалын дүн		2,926,239.0	1,545,001.7

Компанийн НБББББ-т заасны дагуу жил бүрийн эцэст бараа материалын биет тооллого явуулж, чанар байдлыг тодорхойлж, акталж данс бүртгэлээс хасах талаар тооцоо гаргаж компанийн ТҮЗ –д санал оруулж шийдвэрлэдэг.

ТОДРУУЛГА 3.7 ҮНДСЭН ХӨРӨНГӨ

	/мянган төгрөгөөр/	2018	2019
Барилга байгууламж		102,037,675.2	103,689,089.7
Машин тоног төхөөрөмж		112,845,950.8	112,664,159.4
Тавилга эд хогшил		566,839.9	586,122.3
Тээврийн хэрэгсэл		2,110,204.6	2,516,699.7
Компьютер дагалдах хэрэгсэл		669,928.1	882,779.4
Үндсэн хөрөнгийн дүн		218,230,598.6	220,338,850.5

Б. Хуимтлагдсан элэгдэл

	2018	2019
Барилга байгууламж	56,141,867.1	57,045,635.5
Машин тоног төхөөрөмж	82,003,352.9	85,032,629.0
Тавилга эд хогшил	249,368.6	289,249.2
Компьютер дагалдах хэрэгсэл	407,286.5	508,322.1
Тээврийн хэрэгсэл	1,458,267.1	1,559,892.4
Элэгдлийн дүн	140,260,142.2	144,435,728.2

ТОДРУУЛГА 3.8 БИЕТ БУС ХӨРӨНГӨ

	/мянган төгрөгөөр/	2018	2019
Компьютерийн програм хангамж		541,414.5	570,704.5
Бусад биет бус хөрөнгө		6,140.0	1,732.6
Биет бус хөрөнгийн дүн		547,554.5	572,437.1

Б. Хуимтлагдсан элэгдэл

	2018	2019
Компьютерийн програм хангамж	448,433.7	500,081.1
Бусад биет бус хөрөнгө	4,407.3	-592.6

Элэгдлийн дүн

452,841.0

499,488.5

ТОДРУУЛГА 3.9 ХОЙШЛОГДСОН ТАТВАРЫН ӨГЛӨГ

	/мянган төгрөгөөр/	
	2018	2019
Хойшлогдсон татварын өглөг	13,252,861.8	12,836,941.9
Хойшлогдсон татварын өглөгийн дүн	13,252,861.8	12,836,941.9

ТОДРУУЛГА 3.10. ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ

	/мянган төгрөгөөр/	
	2018	2019
Хувийн өмч	1,038,511.6	1,038,511.6
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	63,103,331.0	63,103,331.0
Хуримтлагдсан үр дүн	224,427.5	806,223.5
Эзэмшигчдийн өмчийн дүн	64,366,270.1	64,948,066.1

ТОДРУУЛГА 4. БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО

	/мянган төгрөгөөр/	
	2018	2019
Цахилгааны суурь хураамжийн орлого	1,002,660.6	1,008,633.6
Хэрэглэгчдэд борлуулсан цахилгаан энергийн Орлого	8,784,521.2	59,390,468.0
Хэрэглэгчдэд борлуулсан цахилгааны чадлын Орлого	47,779,383.6	11,837,023.0
Түгээх тусгай зөвшөрөл зээмшигчийн орлого	16,640,544.6	17,717,450.7
Борлуулалтын орлогын дүн	74,206,585.1	89,953,575.3

ТОДРУУЛГА 5. БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ӨРТӨГ

	/мянган төгрөгөөр/	
	2018	2019
Худалдаж авсан цахилгааны үнэ	56,098,899.4	69,275,545.4
Борлуулсан ажил үйлчилгээний өртөг	251,044.9	400,173.1
Борлуулсан бүтээгдэхүүний өртгийн дүн	56,349,944.3	69,675,718.5

ТОДРУУЛГА 6. БОРЛУУЛАЛТ, МАРКЕТИНГИЙН БОЛОН ЕРӨНХИЙ УДИРДЛАГЫН ЗАРДАЛ

	/мянган төгрөгөөр/	
	2019	
Цалин хэлс	3,788,116.1	

Нийгмийн даатгалын шимтгэл	548,604.4
Засвар үйлчилгээний зардал	1,170,384.7
Түрээсийн зардал	1,840.0
Албан томилолтын зардал	109,586.3
Тээврийн зардал	8,131.2
Хангамжийн материалын зардал	0.0
Бичиг хэргийн зардал	34,341.2
Ашиглалтын зардал	129,714.6
Төлбөр хураамж, татварын зардал	150,224.6
Элэгдлийн зардал	3,395,666.7
Сургалтын зардал	88,746.2
Шуудан холбооны зардал	51,659.3
Шатахууны зардал	257,899.6
Даатгалын зардал	23,408.2
Зээлийн хүүгийн зардал	0.0
Цэвэрлэгээ үйлчилгээний зардал	17,368.4
Харуул,хамгаалалтын зардал	73,644.2
Зар сурталчилгааны зардал	17,453.6
Хүлээн авалтын зардал	34,847.0
Мэргэжлийн үйлчилгээний зардал	732,801.9
Үндсэн хөрөнгө солилцоо гарз	0.0
Нийгмийн зардал	386,989.0
Бусад зардал	
Ерөнхий ба удирдлагын зардлын дүн	11,021,427.2

ТОДРУУЛГА 7. БУСАД ЗАРДАЛ

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/	2019
Алданги торгуулийн зардал	52,963.0	
Хандивийн зардал	9,820.0	
Бусад зардал	809,243.4	
Бусад зардлын дүн	872,026.4	

ТОДРУУЛГА 8. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО, ЗАРДАЛ

	/мянган төгрөгөөр/	2018	2019
Үйл ажиллагааны бус орлого	1,808,446.0	1,484,361.8	
Үйл ажиллагааны бус зардал	(1,276,177.4)	(872,026.4)	
Ханшийн зөрүүний олз	1,581.3	358.7	
Ханшийн зөрүүний гарз	(720.6)	(1,441.4)	
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз	-	-	
Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз	-	(66,736.2)	
Үйл ажиллагааны бус орлого, зардлын дүн	533,129.3	544,516.5	

ТОДРУУЛГА 9. САНХҮҮГИЙН ОРЛОГО ЗАРДАЛ

	/мянган төгрөгөөр/	
	2018	2019
Хүүгийн орлого	5,705.9	7,923.8
Түрээсийн орлого	2,060.8	26,859.3
Бусад орлого	1,800,679.3	1,484,361.8
Санхүүгийн зардал	(28,637.8)	(60,923.7)
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз	-	-
Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз	-	(66,736.2)
Санхүүгийн орлого, зардлын дүн	1,779,808.1	1,391,485.0

ТОДРУУЛГА 10. ТАТВАРЫН ТООЦООЛОЛ

	/мянган төгрөгөөр/	
	2018	2019
Татварын өмнөх ашиг	18,121.6	652,959.1
Тусгайлсан хувь хэмжээгээр татвар ногдох	орлого	5,705.9
THO-гоос хасагдахгүй зардал		1,188,898.2
Элэгдлийн зардал- санхүүгийн зорилгоор	6,267,374.0	6,440,059.8
Элэгдлийн зардал – татварын зорилгоор		7,555,085.9
Ханшийн зөрүүний бодит бус олз	1,581.3	
Ханшийн зөрүүний бодит бус гарз	(720.6)	
Татвар ногдуулах орлого		
Хязгаарласан зардлын хэтрэлт		
Нийтлэг хувь хэмжээгээр татвар ногдуулах орлого		699,907.4
Нийтлэг хувь хэмжээгээр ногдуулсан татвар		69,990.7
Тусгайлсан хувь хэмжээгээр ногдуулсан татвар	5,705.9	26,923.8
Татварын зардал	570.6	1,172.4
Нийт төлбөл зохих татварын дүн	18,121.6	71,163.1

ТОДРУУЛГА 11. ХОЛБООТОЙ ТАЛУУД

ДСЦТС ХК-ийн холбоотой тал нь “Хасвuu” ХХК байна.

ТОДРУУЛГА 12. БОЛЗОШГҮЙ ЗҮЙЛ

Өнгөрсөн үйл явдлын үр дүнд хуулийн дагуу эсвэл үүсмэл ямар нэгэн үүрэг, хариуцлага хүлээгээгүй байна.

ТОДРУУЛГА 13. БАЛАНСЫН ДАРААХЬ ҮЙЛ ЯВЦ

Энэхүү тайланг 2019 оны 12 дугаар сарын 31 ний өдрөөр тасалбар болгон 2019 оны 03 дугаар сарын 25-ны өдөр бэлтгэсэн бөгөөд санхүүгийн тайлан тасалбар болгосноос хойш санхүүгийн тайланд залруулагдах үйл явдал гараагүй байна.

Аудитын тайлан бичсэн:

Аудитор
Г.Энхмаа
Аудиторын туслах
Б.Жавзансүрэн

